



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭС**

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 7 дугаар сарын 06 -ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

35. "ХЭЛЭЛЦСЭН нь:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ариутгах татуургын шугам сүлжээ, өргөлтийн насос станц /бохир усны шугам/-ыг Нийслэлийн өмчид (Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ) шилжүүлэх тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 369,241,250.00 (гурван зуун жаран есөн сая хоёр зуун дөчин нэгэн мянга хоёр зуун тавин) төгрөгийн балансын үнэ, 47,062,692.62 (дөчин долоон сая жаран хоёр мянга зургаан зуун ерэн хоёр төгрөг жаран хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий ариутгах татуургын шугам сүлжээ, өргөлтийн насос станц /бохир усны шугам/-ыг Нийслэлийн өмчид (Ус сувгийн удирдах газар) шилжүүлэх асуудлыг дэмжээд, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу Засгийн газар, Улсын Их Хуралд тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэв." гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



000595